



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 01/2022

Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 17.2.9, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний биелэлтийг хангах ажлын хүрээнд байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах 2000000 /хоёр сая/, 5 /тав/ байгаль хамгаалагчдыг мотоциклээр хангах 12500000 /арван хоёр сая таван зуун мянга/, нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион байгуулах 3000000 /гурван сая/, байгууллагын веб сайт, цахим мэдээллийг шинэчлэх 500000 /таван зуун мянга, биотехникийн арга хэмжээ 8000000 /найман сая/, Алтанцөгц, Баяннуур, Ногооннуур сумдад тус бүр 1 /нэг/ булаг шандны эхийг хамгаалж, орчныг тохижуулах 9000000 /есөн сая/, Чигэртэй голын байгалийн цогцолборт газарт биотехникийн арга хэмжээ авах 2000000 /хоёр сая/, Монгол Алтайн нурууны тусгай хамгаалалттай газарт ойжуулалт хийх 3000000 /гурван сая/, гоёл чимэглэл, жимсний модны тарьц суулгацаар хангах 15000000 /арван таван сая/, Алтай Таванбогдын байгалийн цогцолборт газрын төлөвлөсөн маршрутын дагуу отоглох цэг байгуулах 12000000 /арван хоёр сая/, нийт 67000000 /жаран долоон сая/ төгрөгийг Байгаль хамгаалах сангаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Т.Фестиваль/-т зөвшөөрсүгэй.

2. Дээрх санхүүжилтийг зориулалтын дагуу зүй зохистой зарцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Ш.Марат/-т болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс /Х.Анар/-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Д.БАУЫРЖАН

0101220845